

**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ”  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

---

2020 оны 11 дугаар  
сарын 02-ны өдөр

№ 07

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ  
ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалтууд, Санхүүгийн Зохицуулах хорооны “хувьцаат компанийн хурлын зар хүргэх хяналт тавих журам”, “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 7.3, 7.43.3 дах заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ням гарагийн 17.00 цагт БГД, 3 дугаар хороо. Замчдын гудамж. Компанийн төв оффис 84\2 тоотод хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар доор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.
  1. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн “Хувьцаат орон сууц” төслийн явцын тухай тайлан мэдээлэл
  2. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн дүрэмд зарим өөрчлөлт оруулах тухай
  3. Компанийн бонд гаргах тухай
  4. ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин урамшууллын тухай
  5. Бусад асуудлын тухай
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2020 оны 11 дүгээр сарын 26-ны** өдрөөр тогтоосугай.
4. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд хавсралт №1, “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг хавсралт №2, “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг хавсралт №3, “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-

ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал авах хуудсыг хавсралт №4-өөр тус тус баталсугай.

5. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг **2020 оны 12 дүгээр сарын 13-ны өдрийн 17,00 цагаар** тасалбар болгосугай.
6. Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
  - М.Отгонбаатар дарга
  - Ч.Чинбат гишүүн
  - Ш.Нарангаравуу гишүүн

Ээлжит бус хурлын санал авах үйл явцтай холбогдол бүхий бичиг баримтуудыг боловсруулах, баталгаажуулах, санал авах үйл явцыг зохих журмын дагуу зохион байгуулахыг тооллогын комисс /М.Отгонбаатар/-т даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар гүйцэтгэх захирал Н.Алтансүх, гишүүдээр хүний нөөцийн менежер Б.Отгонцацрал, ТУЗ-ийн гишүүн Д.Орхон нарыг тус тус томилсугай.
8. Хурлаар хэлэлцүүлэх бичиг баримтуудыг нэг бүрчлэн компанийн пэйж хуудсанд бүрэн байрлуулахыг дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг удирдах, асуулт хариултыг зохион байгуулах хурлын даргаар ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан, тэргүүлэгчээр ТУЗ-ийн гишүүн Л.Ариунаа нарыг тус тус томилсугай.
10. Хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг гаргахыг компанийн санхүү /Ч.Чинбат/-д даалгасугай
11. Ээлжит бус хурлын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, радио телевизээр 2020 оны 11-р сарын 06-ны өдөр , давтамж зарыг 2020 оны 11-р сарын 21-ны өдөр багтаан мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргэж хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх , танилцуулга бэлтгэх, хурлаас гарах шийдвэрийн төслийг бэлтгэх, хурлаас гарсан шийдвэр, бичиг баримтуудыг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргэх, энэ асуудалтай холбоотой бусад журмын заалтуудыг хэрэгжүүлэхийг комиссын дарга Н.Алтансүх /ажлын алба/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН



## **“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

12. Компанийн ТУЗ-ийн 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хурлаас “НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Ням гарагийн 17.00 цагт БГД, 3 дугаар хороо. Замчдын гудамж. Компанийн төв оффис 84\2 тоотод хуралдуулахаар тогтоолоо.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийг 2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөр тооцно.

### **Ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ**

1. ““Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн “Хувьцаат орон сууц” төслийн явцын тухай тайлан мэдээлэл
2. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн дүрэмд зарим өөрчлөлт оруулах тухай
3. Компанийн бонд гаргах тухай
4. ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин урамшууллын тухай
5. Бусад асуудлын тухай

Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн үйлчлүүлдэг БДК дээр ажлын өдрүүдэд /даваа-баасан/ 9.00-16.00 цаг хүртэл авах боломжтой ба “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн пейж хуудсаар нээлттэй авах боломжтой болно.

Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдтэй холбоо барих, мэдээлэл авах утас:  
**Н.Алтансүх 99276519, М.Отгонбаатар 91918840**

Имэйл хаяг: [Jinst\\_Altansukh@yahoo.com](mailto:Jinst_Altansukh@yahoo.com)

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны  
11 дүгээр сарын 02-ны өдрийн  
07 тоот тогтоолын "Хавсралт №2

**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ЖК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДЭГ**

6. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 17.00 цагт БГД, 3 дугаар хороо. Замчдын гудамж. Компанийн төв оффис 84\2 тоотод хуралдуулахаар тогтоосугай.

№	Агуулга	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэн гаргах /комисс/	2020.12.13. 17.00 цаг
2	Хурлаар хэлэлцэх үндсэн асуудлуудыг хэлэлцэх Хэлэцсэн асуудалтай холбоотой асуулт, хариулт	Цаг тогтохгүй Хүн тус бүр 5 минут хүртэл
3	Хэлэлцсэн асуудлын талаар санал гаргах	Хүн тус бүр 5 минут
4	Санал хураалт	Цаг тогтоохгүй
5	Хурлаас гарах шийдвэрийн тогтоолын төслийг танилцуулах, батлах	Цаг тогтоохгүй

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны  
11 дүгээр сарын 02-ны өдрийн  
07 тоот тогтоолын "Хавсралт №3

**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ**

“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд дараах бичиг баримтыг танилцуулна.

- “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн “Хувьцаат орон сууц” төслийн явцын тухай тайлан мэдээлэл
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай тогтоол болон хавсралтууд
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар санал авах хуудасны загвар
- Ээлжит хурал зарласантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн зайлшгүй мэдэх ёстой бусад мэдээлэл

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны  
11 дүгээр сарын 02-ны өдрийн  
07 тоот тогтоолын "Хавсралт №4

## “НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУСХУРАЛД САНАЛ АВАХ САНАЛЫН ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр.....  
Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар .....  
Эзэмшиж буй хувьцааны тоо.....  
Бүртгэсэн үнэт цаасны компанийн нэр.....  
Брокерийн овог.....нэр.....

1. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 17.00 цагт БГД, 3 дугаар хороо. Замчдын гудамж. Компанийн төв оффис 84\2 тоотод хуралдана .

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн “Хувьцаат орон сууц” төслийн явцын тухай тайлан мэдээлэл			
2	“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн дүрэмд зарим өөрчлөлт оруулах тухай			
3	Компанийн бонд гаргах тухай			
4	ТУЗ-ийн дарга. гишүүдийн цалин урамшууллын тухай			
5	Бусад асуудлын тухай			

Брокер.....Гарын үсэг

/тэмдэг/

Хувьцаа эзэмшигч.....Гарын үсэг

2020 оны.....сар.....өдөр

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**